

Монгол Улс
НЭЗХДШ болон ТС-ийг боловсруулах хүрээнд Өмнөговь аймгийн засаг захиргааны
төлөөлөлтэй хийсэн уулзалт
2017 оны 9-р сарын 14

Тус тэмдэглэл нь уулзалтын явцад дэвшүүлсэн асуудлын товч, албан бус тойм юм. Хэрвээ та энэ уулзалтанд оролцсон бөгөөд тэмдэглэлд засвар оруулах эсвэл нэмж мэдээлэл өгөхийг хүсвэл ibaatarkhuu@worldbank.org и-мэйл хаягаар Б. Индратай холбогдоно уу.

Дэлхийн Банк Групп нь (ДБГ) Монгол Улсын хөгжлийн боломж, сорилт, тулгамдсан асуудал болон ДБГ-ээс Монгол Улсад үзүүлж болох дэмжлэгийн талаар санал бодлоо солилцох зорилгоор 2017 оны 9 дугаар сарын 14-нд Өмнөговь аймгийн засаг захиргаа, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 20 төлөөлөлтэй уулзлаа.

Хэлэлцүүлгийг дараах үндсэн гурван асуудлын хүрээнд хийлээ:

1. Таны бодлоор Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг хангахад ямар гол боломж, сорилт, бэрхшээл тулгамдаж байна вэ?
2. Таны бодлоор дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсын хөгжлийн нэн тэргүүний зорилго юу байх вэ?
3. Дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг тогтвортойгоор хангахын тулд ДБГ (Дэлхийн Банк, ОУСК, ОТХОБА) Монгол Улсад хэрхэн тусалж, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ?

Ангилал	Оролцогчдын санал
<p style="text-align: center;">Дүн шинжилгээний баримт бичигт тусгах санал (боломж, сорилт, тулгамдсан асуудал ба ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжих арга замууд)</p>	<p>Боломж:</p> <ul style="list-style-type: none"> • Монгол улс нь том нутаг дэвсгэр, баялаг ихтэй, 3 сая хүн амтай, 60 сая гаруй толгой малтай. Гэвч энэ баялгийг бид хэрхэн зөв ашиглаж байна вэ гэдэг асуулт бий. Нэг хүнд ногдох ДНБ, хүний хөгжлийн үзүүлэлтүүд нь эдгээр боломжуудтай харьцуулахад доогуур байна. Хэрэв бид тогтвортой зөв бодлого хэрэгжүүлбэл хүн амын амьжиргааг дээшлүүлэхэд харьцангуй хялбар байх болно. • Монгол улсын хэмжээнд замын дэд бүтцийг хөгжүүлэхэд ихээхэн ахиц дэвшил гарсан. • Орон нутгийн ЖДҮ-ийг хөгжүүлэх, томоохон уул уурхайн төслүүдэд бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх боломж их бий. • Уул уурхайн нөөц нь сэргээгдэхгүй нөөц, харин ард түмний ухаан, оюуны нөөц, мэдлэг нь үл шавхагдах оюуны баялаг учраас илүү ашиглах ёстой. <p>Сорилт:</p> <p>Хөдөө аж ахуй</p> <ul style="list-style-type: none"> • Мал аж ахуйн салбарыг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх ёстой боловч энэ салбар нь цаг агаарын байдлаас ихээхэн хамааралтай юм. Тус аймаг нь 3 сая гаруй толгой малтай боловч цаг агаарын хатуу ширүүн нөхцөл байдал, малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах чадваргүйн улмаас малчдын амьжиргаа маш эмзэг байдаг. Үүнийг шийдвэрлэхийн тулд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд суурилсан эрчимжсэн мал аж ахуй, боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх нь зүйтэй. • Малчид малын гаралтай бүтээгдэхүүнийг эцсийн хэрэглэгчдэд шууд борлуулах боломжгүй байдаг. Ченжүүд малын гаралтай бүтээгдэхүүний борлуулалтаас ихэнх ашгийг авдаг учраас малчид орлогоо нэмэгдүүлэх боломж багатай. • Удаан хугацаагаар хадгалах боломжтой сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх хэрэгтэй. Зун, намрын улиралд түүхий сүүг их хэмжээгээр цуглуулах, цуглуулсан түүхий сүүгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх

үйлдвэрүүдийг бий болгох өртгийн сүлжээ бий болгох замаар үүнийг хэрэгжүүлж болно.

Аялал жуулчлал

- Аялал жуулчлалын дэд бүтцийг сайжруулж, иргэдийг чадавхжуулснаар аялал жуулчлалыг бүрэн ашиглах боломжтой. Одоогийн байдлаар орон нутгийн түвшинд жуулчдад үзүүлж буй үйлчилгээ, бүтээгдэхүүн нь маш энгийн бөгөөд жуулчдад чанартай үйлчилгээ үзүүлж, чанартай бүтээгдэхүүн нийлүүлэхэд гол анхаарлаа хандуулах ёстой. Ингэснээр орон нутгийн иргэдийн орлогын нэмэлт эх үүсвэр бий болно.

Дэд бүтэц

- Өмнөговь аймгийн сумд хоорондоо их алслагдсан, хамгийн хол сум нь аймгийн төвөөс 300 орчим км-ийн зайтай байдаг. Иймд дэд бүтцийг дэмжсэн санхүүжилт их шаардлагатай.

Боловсрол

- Ядуурлыг бууруулахад хамгийн чухал үүрэг гүйцэтгэдэг бага насны хүүхдийн боловсролын төслүүд нь Дэлхийн Банкны нийт санхүүжилтийн багахан хувийг эзэлдэг. Цэцэрлэгийн наснаас нь эхлэн хүүхдэд Монголын уламжлалт нүүдэлчин соёл, зан заншлыг заах хэрэгтэй.
- Чанарыг сайжруулахад голлон анхаарч дээд боловсролын шинэчлэлийг хэрэгжүүлэх хэрэгтэй. Чанарын ямар ч хяналтгүйгээр дээд боловсролын хэтэрхий олон тооны байгууллага байгуулагдсан.
- Боловсролын зарим бодлого нь малчдын нийгмийн амьдралд нөлөөлж байна- малчин өрхийн хувьд эх нь аймаг, сумын төвд бага насны хүүхдээ халамжлан амьдарч байхад эцэг нь хөдөө малаа хариулж үлдэх шаардлагын улмаас эхнэр, нөхөр тусдаа амьдрахад хүрч байна. Иймд боловсролын бодлого болон бусад салбарын бодлого зохицуулалт нь уламжлалт амьжиргааны үнэ цэнэ, малчдын амьдралын хэв маягт нийцсэн байвал зохино.

Уул уурхай

- Уул уурхайн салбарын хөгжил нь Монгол улсын хөгжлийн хүчин зүйлсийн нэг байв. Гэвч нэг салбараас хэт хамааралтай байх нь тогтворгүй байдлыг бий болох учраас аялал жуулчлал, мал аж ахуйн үйлдвэрлэлд түшиглэн эдийн засгийг төрөлжүүлэхэд анхаарах хэрэгтэй.
- Бэлчээрт нөлөөлдөг учраас малчид Монгол улсад уул уурхайг хөгжүүлэхийг ихээхэн эсэргүүцдэг. Гэвч нөгөө талаас иргэдийг тэнцвэртэй мэдээллээр хангахын тулд уул уурхайн төслүүдийн үр өгөөжийн талаар илүү дэлгэрэнгүй, үнэн зөв мэдээллээр хангахад хүчин чармайлт гаргах хэрэгтэй.
- Хууль бусаар ашигт малтмал олборлогчид буюу бичил уул уурхай эрхлэгчид нь ажилгүйчүүдийн бүртгэлд бүртгүүлснээр халамжийн хөтөлбөрүүдээс тэтгэмж авдаг, орлогоо тайлагнадаггүй.
- Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулж буй уурхайн төлдөг орлого, татвар улсын төсөвт төвлөрдөг учраас орон нутгийн ард иргэд уул уурхайн үр өгөөжийг хүртэж чаддаггүй. Өмнө нь уул уурхайн салбараас хуримтлагдсан татварын орлогын зарим хэсгийг аймгууд авч, Орон нутгийн хөгжлийн санд хадгалах боломжтой байсан. Энэ засгийн газрын үед энэ хувь хэмжээг ихээр бууруулсан. Ийм хүчин зүйлийн улмаас орон нутгийн иргэд, оршин суугчид уул уурхайн төслүүдийг орон нутагтаа хэрэгжүүлэхийг хүсдэггүй, уул уурхайн компаниуд болон орон нутгийн иргэдийн хооронд хурцадмал байдлыг бий болгоход нөлөөлж байна.

	<p>Байгаль орчин, бохирдол</p> <ul style="list-style-type: none"> Улаанбаатар хотын агаарын бохирдол нь нэн чухал асуудал болсон түүнчлэн аймаг, сумын төвүүдэд ч агаарын бохирдол нэмэгдсээр байна. Агаарын бохирдлыг улам дордохоос нь өмнө одооноос анхаарч шийдвэрлэх шаардлагатай юм. <p>Засаглал</p> <ul style="list-style-type: none"> Хэрэв Монгол улс илүү тогтвортой бодлого хэрэгжүүлбэл хөгжих боломж их бий. Төрийн бодлого, төрийн албан хаагчид тогтмол өөрчлөгдөх нь Монгол улсын хөгжлийг сааруулж байна. Бүсийн хөгжлийн стратегит аймаг тус бүрийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тусгах ёстой. Жишээ нь, нэг сум тодорхой салбарыг хөгжүүлэхэд илүү давуу талтай байхад бусад сумд тухайн салбарт өрсөлдөх чадваргүй байх гэх мэт. <p>Эдийн засгийн хөгжил, ажлын байх, ядуурал:</p> <ul style="list-style-type: none"> Орон нутгийн ЖДҮ-үүд ОТ-н уурхайд бүтээгдэхүүнээ нийлүүлэх туршлагагүй байна. Орон нутгийн иргэд ажлын байр бий болгох, ЖДҮ-үүдээр дамжуулан ханган нийлүүлэлт хийх гэх мэтээр томоохон төслүүдийн үр өгөөжийг илүү хүртэх боломжийг бүрдүүлэхийн тулд орон нутгийн ЖДҮ-үүдийг чадавхжуулахад төрөөс бодлого, хөтөлбөрийн дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Уул уурхайн компаниудад улс төрийн хөндлөнгийн оролцоо их байдгаас тухайн уул уурхайн компаниудад бүтээгдэхүүн, үйлчилгээ ханган нийлүүлэгчдийн хооронд шударга өрсөлдөөн байдаггүй. Бүх ЖДҮ-үүдэд шударга өрсөлдөх боломжийг олгох ёстой. Түүнчлэн уул уурхайн төслүүдийн техник эдийн засгийн үндэслэлийн судалгаа нь тухайн орон нутгийн ЖДҮ, компаниуд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ уул уурхайн томоохон төслүүдэд ханган нийлүүлэх орон зайг судалж тусгах нь зүйтэй. Боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх нь орон нутгийн хөгжилд тэргүүлэх ач холбогдолтой. Ядуурлыг бууруулахын тулд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тодорхой хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх нь зүйтэй. Зээлийн хүү өндөр байгаа нь айл өрх, аж ахуйн нэгжүүдэд дарамт болдог. Энэ нь иргэдийн амьжиргааг доройтуулж, ядуурлыг нэмэгдүүлж буй гол хүчин зүйл юм. Хөдөө орон нутагт үйл ажиллагаагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн татварын хувь хэмжээ нь хэтэрхий өндөр буюу ойролцоогоор нийт орлогын 40 орчим хувь нь татварт хураагдаж байгаа нь ядууралд нөлөөлж байна. <p>Эрүүл мэнд</p> <ul style="list-style-type: none"> Ахмад настан, малчдын эрүүл мэнд, сайн сайхан байдлыг үл хайхардаг. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, хувь хүний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд одооноос анхаарч эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог илүү боловсронгуй болгох шаардлагатай. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрүүл мэнд ерөнхийдөө доройтож байгаа нь сэтгэл түгшээсэн асуудал болсон. Хүн амын эрүүл мэндийг сайжруулахын тулд нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн боловсрол, урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдийг нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай байна.
	<p>Хандлага ба хэрэгжилт</p>

ДББ-ийн стратеги ба түншлэлийн баримт бичигт тусгах санал	<ul style="list-style-type: none"> Өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн зарим төслүүд орон нутагт үр дүнтэй хэрэгжсэний нэг жишээ бол орон нутгийн иргэдийн дунд сайн мэддэг Тогтвортой амьжиргаа төсөл юм. Гэвч Дэлхийн Банкны дэмжлэгтэйгээр Өмнөговь аймагт хэрэгжиж буй бусад төслүүдийн тухай мэдээлэл байдаггүй. Иймд бусад төслүүдийн талаар илүү мэдээлэл өгөх нь зүйтэй.
	<p>Салбарууд</p> <ul style="list-style-type: none"> ДБГ нь авилгалаас урьдчилан сэргийлэх, авилгалтай тэмцэх, төрийн албан хаагчид болон нийгмийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Төрийн төвлөрлийг сааруулах, төрийн янз бүрийн агентлаг хоорондын зохицуулалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх хүсэлт гаргах. Иргэд уул уурхайн компаниудад бүтээгдэхүүнээ нийлүүлэхийн тулд янз бүрийн салбарыг хөгжүүлэхийг хүсч байгаа боловч ЖДҮ-ийн талаарх мэдлэг, санхүүжилт дутмаг байгаагаас дорвитой ахиц гарахгүй байна. Үүнийг дэмжихийн тулд Дэлхийн Банкнаас санхүүгийн дэмжлэг, зөвлөх үйлчилгээ үзүүлэхийг хүссэн. Ашигт малтмалын нөөцийн удирдлагыг сайжруулах, боловсруулах үйлдвэрийг дэмжихэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, зөвлөх нь нэн тэргүүнд чухал байна. Бизнес инкубаторын төвүүдийг аймгуудын түвшинд хөгжүүлэх хэрэгтэй.

Уулзалтын үеэр авсан судалгааны дүн:

- Ирэх 10 жилийн хугацаанд ядуурлыг устгаж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжихийн тулд Монгол Улс аль чиглэлээр хөгжихөд голлон анхаарах ёстой вэ? (Боломжит хариултуудаас 5 хүртэлх хариултыг сонгоно уу)

• Төрийн удирдлага/шинэтлэл	4	40%
• Боловсрол	4	40%
— Авилгатай тэмцэх	3	30%
— Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг хянах	3	30%
— Хувийн хэвшлийг хөгжүүлэх	1	10%
— Ажлын байр бий болгох/хөдөлмөр эрхлэлт	1	10%
— Хөдөө аж ахуй, мал аж ахуй, ойн сан	1	10%
— Эрүүл мэнд	1	10%
— Хүнсний аюулгүй байдал	1	10%
— Хотын хөгжил	1	10%
— Нийгмийн хамгаалал	1	10%
— Байгалийн нөөцийн удирдлага	0	0%
— Хөдөөгийн хөгжил	0	0%
— Эдийн засгийн өсөлт	0	0%
— Гамшгийн эрсдлийн удирдлага	0	0%

— Эрх тэгш боломжоор хангах	0	0%
— Санхүүгийн зах зээл	0	0%
— Гадаадын хөрөнгө оруулалт	0	0%
— Зам, тээвэр	0	0%
— Худалдаа, экспорт	0	0%
— Эрчим хүч	0	0%
— Ус, ариун цэврийн байгууламж	0	0%
— Уур амьсгалын өөрчлөлт	0	0%
— Бусад:	0	0%

2. Дараагийн 4-6 жилийн хугацаанд ДББ Монгол Улсыг аль чиглэлд дэмжвэл хамгийн их үр дүнтэй гэж та үзэж байна вэ? (Боломжит хариултуудаас 3 хүртэлх хариултыг сонгоно уу)

— Хүний хөгжлийг дэмжих	5	50%
— Байгалийн нөөцийн удирдлага, байгаль орчныг хамгаалах чиглэлээр дэмжих	3	30%
— Төрийн удирдлага, засаглалын чиглэлээр дэмжих	3	30%
— Бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр дэмжих	1	10%
— Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих	1	10%
— Дээрх бүгд чухал	0	0%